

**Сор Хувьцаат Компанийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл**

2019.04.27

Улаанбаатар хот

Хурал болсон газар: Улаанбаатар хот, хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Сор ХК-ийн байр, Хурлын танхим.

Эхэлсэн он, сар, цаг: 2019 оны 04 сарын 27-ны өдөр 10:00 цаг

Дууссан он, сар, цаг: 2019 оны 04-р сарын 27-ны өдөр 11:00 цаг

Хурлыг компанийн ТУЗ-ийн дарга Ишхүү овогтой Дариймаа удирдаж хурлыг нээж Хувь нийлүүлэгчдийн хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комисс, хурал зохион байгуулах комисс томилсон ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулан хурал зохион байгуулах комиссыг ажилдаа орохыг мэдэгдэв.

Хурлын дарга: ТУЗ-ийн дарга И.Дариймаа

Хурлын нарийн бичгийн дарга: Г.Уянга

Тооллогын комисс: Дарга Д.Сүхээ, Гишүүн Н.Баярмаа нар

Хурал зохион байгуулах комисс: Дарга Е.Булгансайхан, Гишүүн Ц.Цэцгээ нар тус тус ажиллав.

Хурал зохион байгуулах комисс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэн баталгаажуулж хурлын ирцийг мэдээлэв.

- Хурлын даргад хурлын ирцийн мэдээг мэдээлэхэд:

Сор ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 891,388 ширхэг санал ирэхээс 672,110 саналын эрхтэй гишүүд ирсэн ба төлөөлөн оролцох итгэмжлэлээр 4 хувь нийлүүлэгч, 7 хувь нийлүүлэгч биеэр ирсэн байна. Хурлын ирц 75.4% байна.

1. Сор ХК-ийн нийт хувьцааны 47.1% буюу 420,671 ширхэг хувьцааг эзэмшигч Блю скай кашемир ХХК-ийг төлөөлж Л.Одгэрэл /итгэмжлэлтэй/
2. Сор ХК-ийн нийт хувьцааны 16.9% буюу 151,000 ширхэг хувьцааг эзэмшигч Титан Инвест ХХК-ийг төлөөлж О.Золсайхан /итгэмжлэлтэй/
3. Сор ХК-ийн нийт хувьцааны 8.45% буюу 75,337 ширхэг хувьцааг эзэмшигч Монгол даатгал ХХК-ийг төлөөлж Н.Батбаяр /итгэмжлэлтэй/
4. Сор ХК-ийн нийт хувьцааны 2,79% буюу 24,897 ширхэг хувьцааг эзэмшигч А.Дүүрэнбилэгийг төлөөлж П.Гантуяа /итгэмжлэлтэй/
5. Сор ХК-ийн нийт хувьцааны 1 ширхэг хувьцааг эзэмшигч Б.Ганболд
6. Сор ХК-ийн нийт хувьцааны 70 ширхэг хувьцааг эзэмшигч Ж.Мэндгэрэл
7. Сор ХК-ийн нийт хувьцааны 1 ширхэг хувьцааг эзэмшигч Ж.Азбаяр
8. Сор ХК-ийн нийт хувьцааны 1 ширхэг хувьцааг эзэмшигч Б.Дуламжав
9. Сор ХК-ийн нийт хувьцааны 35 ширхэг хувьцааг эзэмшигч Б.Энхтуяа
10. Сор ХК-ийн нийт хувьцааны 97 ширхэг хувьцааг эзэмшигч Ц.Тумбааш

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж хурлын дарга И.Дариймаа үг хэлэв.

- Сор ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл, Компанийн тухай хууль болон Сор ХК-ийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд хуралдуулах шийдвэр гаргаж зарлан хуралдуулж байна. Хурал хуралдуулах бүх бэлтгэлийг хуулийн дагуу явуулсан бөгөөд өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 75.4% байна. Тус



компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нь Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-т заасны дагуу саналын эрх бүхий хувьцааны 50%-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцож байгаа тул тус хурал хүчин төгөлдөр болж байна. Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах хуулийн ирцийг хангасан тул Сор ХК-ийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдье. Мөн нэмж хэлэхэд бид урьд урьдын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ажлын өдөр зохион байгуулдаг байсан ба маш цөөхөн хувьцаа эзэмшигчид оролцдог байсан. Тэр болгон хувьцаа эзэмшигчид ажлын цагаа хагаслан байж ирэх боломжгүй байдаг учир энэ удаад зориуд амралтын өдөр зохион байгуулж байгаа явдал нь олон хувьцаа эзэмшигчдийн дуу хоолой, санал бодлыг нь сонсох зорилготой юм аа.

Хурлын дарга И.Дариймаа: Өнөөдрийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Үүнд:

1. Сор ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Хурлын дарга И.Дариймаа хурлын дэгийг танилцуулав.

Үүнд:

- Хурлын тэргүүлэгчдийг сонгох, батлах
- Хэлэлцэх асуудал
 - а/ Сор ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
- Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт

Хүн тус бүр	/15 мин/
-------------	----------
- Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон санал, шүүмжлэл

Хүн тус бүр	/15 мин/
-------------	----------
- Санал хураалт явуулах; /10 мин/
- Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагаа явуулна; /20 мин/
- Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах; /10 мин/
- Хурлаас гарах шийдвэрийн төслийг хурлын дарга танилцуулж, батлуулах; /10 мин/
- Ногдол ашиг хувиарлаагүй тухай танилцуулах /10 мин/
- Ногдол ашиг холбогдсон асуулт, хариулт

Хүн тус бүр	/15 мин/
-------------	----------
- Хурлыг 2 цагт багтаан хуралдуулна. (Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.)

Хурлын дарга И.Дариймаа: Хурлын дэгийн дагуу хурлын тэргүүлэгчдийг сонгоё.

Хурал зохион байгуулах комиссоос Хувьцаа эзэмшигчидэд Хурлын тэргүүлэгчээр И.Дариймаа, Е.Булгансайхан нарыг сонгох санал тавив.

Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид бүгд саналыг дэмжив.

Хурлын дарга И.Дариймаа: Батлах уу?

Хуралд оролцсон бүх хувьцаа эзэмшигчид батлав саналтай байна.

Хурлын дарга И.Дариймаа:

- Хурлаар хэлэлцэх асуудал. Сор ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн дарга И.Дариймаа танилцуулна.

ТУЗ-ийн дарга И.Дариймаа:

- Сор ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Тус компани нь Монгол улсын хууль, Компанийн тухай хууль, НББ болон Татварын хууль, бусад хууль дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн ТУЗ нь 2018 онд хоёр удаа хуралдаж хоёр асуудал хэлэлцэн тогтоол гаргасан болно.

Компанийн ТУЗ нь Сор ХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, одоогийн нөхцөл боломжит зах зээлийг олох, Олон улсын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж, техник технологийг нэвтрүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэтийн зорилтыг тавин Гүйцэтгэх захиралд үүрэг болгон ажиллаж байна. Компанийн хувьд одоогийн байдлаар түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашдаа жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулахаар судалгаа хийж байна. Өнөөдрийн байдлаар “Ус суваг удирдах газар”-ын Урьдчилан цэвэрлэх байгууламж нь арьс ширний хашаанд байрлах үйлдвэрүүдийн бохирын ачааллаа дийлэхгүй байгаа нь манай байгууллагын хувьд багагүй асуудал болж байна. Учир нь арьс ширний нэгдлийн хашаан дотор байрлах үйлдвэрүүд нь нийтийн эзэмшлийн талбай болон авто машины зам, явган хүний зорчих хэсэг гэх мэт газруудаар үйлдвэрийн технологийн бохир усаа шууд задгай асгаж байгаа нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Үүний улмаас компанийн хүрээлэн буй орчинд шууд сөргөөр нөлөөлж, явган хүн болон автомашин явахад ч нэн бэрх болоод байгаа ба манай компанид ч мөн адил үйлчилж байна. Одоогийн байдлаар компанийн хүрээлэн буй орчны нөлөө хэт их бохирдолтой, буюу эрсдэл өндөр байгаа тул арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх хүртэл компанийн үйл ажиллагаанд дорвитой дэвшилт гаргах боломжгүй байна.

2018 онд 4878 м² талбай түрээслүүлж 212,4 сая төгрөгийн орлоготой ажилласан. Харин үйл ажиллагааны зардлын нийт дүн 160,6 сая төгрөг болсон ба 46,6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Нийт зардлын дүнгийн 13% нь ерөнхий удирдлагын зардал, 46,8%-ийг цалингийн зардал, 1,4%-ийг засвар үйлчилгээний зардал, 16,6%-ийг элэгдлийн зардал, 22,2%-ийг бусад зардал эзэлж байна.

- Хувьцаа эзэмшигч Ц.Тумбааш: Үйл ажиллагааны талаар, цаашид ямар бодлого баримтлан ажиллах эсэх талаар асуув.
- ТУЗ-ийн дарга И.Дариймаа: Сор ХК нь одоогийн байдлаар өөрийн үндсэн үйл ажиллагаагаараа байгаа гэрчилгээнд бичигдсэн. Гэхдээ бид үндсэн үйл ажиллагаа явуулах боломжгүй. Иймд түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаас өөр гарц шийдэл байхгүй байна. Бид олон талын судалгаа хийж байгаа боловч төсөв, хөрөнгө оруулалт байхгүй учраас үйлдвэрлэлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулах боломж

- ойрын хугацаанд байхгүй байна. Үйл ажиллагааны үндсэн орлого нь ердөө л түрээсийн орлого боллоод байна.
- Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: м² хэдэн төгрөгийн ханштай түрээсэлж байгаа вэ?
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: м² үнэ НӨАТ-тай 5,500 төгрөгөөр түрээсэлж байна. Бид түрээслэгч нараар өөрсдөөр нь засвар үйлчилгээ хийлгэн түрээсийн төлбөрөөс хөнгөлөлт үзүүлэн барилгаа дахин сэргээж ашиглаж байна.
 - Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: одоо хэдэн м² талбай түрээсэлж байна вэ?
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: Оффис болон үйлдвэрийн барилга нийт 20,000 гаруй метр квадрат талбайтай. Одоо үйлдвэрийн байрны 1, 2 давхар 3 давхарын тал талбай, конторын 1, 5 давхар түрээсэлж байна. Бусад үлдсэн хэсэг нь хоосон байгаа. Бид арьс ширний үйлдвэрүүдийн бохир ус асгадаг зэрэг орчны нөлөөллөөс хамааран түрээслэгчид бага хэрэв зам дагуу орчны нөхцөл байдал хэвийн байсан бол түрээслэх сонирхолтой аж ахуй нэг их байдаг. Үйлдвэрийн 1, 2 давхар, конторын 2 давхрыг Блю скай кашемир ХХК, үйлдвэрийн 3 давхрын хагасыг Пи Си Вай ХХК, Үйлдвэрийн урд хэсгийг ноос угаадаг Жи ЭС Фи ХХК тус тус түрээсэлж байна. Түрээсийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш буюу 2016 оноос эхлэн баланс нэмэхтэй гарсан байгаа. Энэ нь их хэмжээний биш ч гэсэн 2018 онд татвар төлсний дараа 46 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.
 - Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: тайлан тэнцэл дээр байгаа өр төлбөр нь юуны өр төлбөр вэ?
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: энэ өр төлбөр нь 7 тэрбум байгаа байх мөн авлага нь 7 тэрбум байгаа өглөг авлагын харьцаа ижил байгаа. Энэ нь ямар учиртай вэ гэхээр Блю скай кашемир ХХК нь анх энэ байранд нүүж орохдоо Сор ХК-иар дамжуулан зээл авч Сор ХК-ийн байранд бүрэн капитал засвар хийсэн. Энэ зээлийг Блю скай кашемир ХХК хариуцаж барагдуулж байгаа. Өөрөөр ямар нэгэн өр, авлага байхгүй байгаа.
 - Хувьцаа эзэмшигч Ж.Мэндгэрэл: Сор ХК-ийн өмчлөлийн газар нийт хэдэн га газар байгаа вэ?
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: Энэ газар нь Сор ХК-ийн эзэмшлийн 14,000 гаруй м² газар байгаа. Өмчлөлийн биш.
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан өөр асууж тодруулах зүйл байна уу?
 - Хувьцаа эзэмшигч Блю скай кашемир ХХК Л.Одгэрэл: Хэлэлцэж байгаа асуудлын талаар танилцуулга уншиж танилцлаа, мөн сонслоо надад асуух зүйл байхгүй гэв.
 - Хувьцаа эзэмшигч Монгол Даатгал ХХК Н.Батбаяр: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
 - Хувьцаа эзэмшигч Титан инвестицйг төлөөлж О.Золсайхан: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
 - Хувьцаа эзэмшигч Ж.Азбаяр: Дараа дараагийн ирээдүйн төлөвлөгөө юу байгаа вэ?
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: Сор ХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, одоогийн нөхцөл боломжит зах зээлийг олох, Олон улсын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж, техник технологийг нэвтрүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэтийн зорилтыг тавин Гүйцэтгэх захиралд үүрэг болгон ажиллаж байна.
 - Хувьцаа эзэмшигч А.Дүүрэнбилэгийн төлөөлөгч Л.Гантуяа: төсөл хөтөлбөр боловсруулж үзсэн үү төрөөс дэмжих болов уу?
 - ТУЗ-ийн дарга И.Дариймаа: бид төсөл өгсөн. Төрөөс дэмжээгүй. Засгаас арьс ширний хашаанд байрлах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлнэ, орон сууцжуулна гэсэн хариу өгсөн.

- Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
- Хувьцаа эзэмшигч Ж.Мэндгэрэл: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
- Хувьцаа эзэмшигч Ж.Азбаяр: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
- Хувьцаа эзэмшигч Б.Дуламжав: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
- Хувьцаа эзэмшигч Б.Энхтуяа: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.
- Хувьцаа эзэмшигч Ц.Тумбааш: Асууж тодруулах зүйл байхгүй гэв.

Хурлын дарга И.Дариймаа хэлэлцэж байгаа асуудлаар хэлэлцэж дууссан талаар танилцуулав.

Хурлын дарга И.Дариймаа:

- Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-өөс гарсан тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн Гүйцэтгэх захирал танилцуулна.

Гүйцэтгэх захирал Е.Булгансайхан:

- Сор ХК-ийн ТУЗ нь 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдөр хуралдаж Дугаар 19/01 тоот "Ногдол ашиг хуваарилахгүй тухай" тогтоол гаргасан. Тус тогтоолыг уншиж танилцуулая.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.6 дахь хэсэг, "Төлөөлөн удирдах зөвлөл"-ийн 2019 оны 02-р сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Сор хувьцаат компани нь 2018 оны байдлаар нийт 46,676,256 /дөчин зургаан сая зургаан зуун далан зургаан мянга хоёр зуун тавин зургаа/ төгрөгийн ашигтай ажилласан ба ногдол ашиг хуваарилахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс бага, төлбөрийн чадваргүй байх тул тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.
2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Е.Булгансайхан/-д үүрэг болгосугай.
ТУЗ-ийн дарга И.Дариймаа, ... гарын үсэг, ... тамга.

Гүйцэтгэх захирал Е.Булгансайхан:

- Сор ХК-ийн хувьд 2018 оны байдлаар нийт 46,676,256 төгрөгийн ашигтай ажилласан хэдий ч ногдол ашиг хуваарилах боломжгүй байна. Энэ талаар та бүхэнд ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулахад ойлгомжтой байсан байх гэж бодож байна.
- Хувьцаа эзэмшигчид дүгнэлттэй холбоотой асууж тодруулах зүйл байна уу?
- Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид асууж тодруулах зүйл байхгүй гэв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч А.Дүүрэнбилэгийг төлөөлж Л.Гантуяа, Б.Ганболд, Ж.Мэндгэрэл, Ж.Азбаяр, Б.Дуламжав, Б.Энхтуяа, Ц.Тумбааш нар нь хувьцаагаа худалдах саналтай байгаагаа мэдэгдэв. Мөн Сор ХК нь хувьцаагаа худалдан авах сонирхолтой байгаа эсхүл том хувьцаа эзэмшигч нар жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах эсэх талаар сонирхож байгаа талаар хувьцаа эзэмшигчид харилцан санал солилцов.

Хурлын дарга И.Дариймаа:

- Сор ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн талаар хувьцаа эзэмшигчид хэлэлцэж дууслаа.

Хурал зохион байгуулах комисс:



Сор ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

- 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын талаар саналын хуудсаар санал авна. Саналын хуудсыг өгөгдсөн зааврын дагуу бөглөж санал хураах хайрцагт хийнэ үү.

Тооллогын комисс: Хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг тоолж танилцуулав.

- Сор ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд компанийн нийт хувьцааны 75.45% буюу 672,110 ширхэг саналын эрхтэй, 10 хувьцаа эзэмшигчээс санал хураах хуудсанд нэг асуудлаар санал хураахад хүчинтэй 10 ширхэг саналын хуудас гарч, хүчингүй 0 ширхэг саналын хуудас гарсан бөгөөд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигч асуудлыг 100% зөвшөөрсөн байна. Мөн брокерийн пүүсүүдээр дамжуулж ирсэн санал байхгүй байна.

Хурлын дарга И.Дариймаа хурлаас гарах шийдвэр танилцуулав: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигч 100% дэмжсэн, Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн дараах шийдвэр гаргаж байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Сор ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.

Хурлын дарга хурал өндөрлөснийг мэдэгдэж үг хэлэв.

- Сор ХК-ийн энэ оны ээлжит хурал амжилттай болж өнгөрлөө хурлаар хэлэлцсэн асуудалд санал өгч, хуралдаа амжилттай оролцсон та бүхэнд баярлалаа. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа, дахин дахин хуралдаа идэвхтэй оролцоорой бид урьд урьдын хурлыг ажлын өдрүүдэд хуралдуулдаг байсан бол энэ удаад олон хувьцаа эзэмшигчдийн саналыг сонсох үүднээс амралтын өдөр зохион байгууллаа. Амралтын цагаа хагаслан ирж хуралдаа оролцсон та бүхэнд талархал илэрхийлье. Ингээд хурал өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа баяртай.

Тэмдэглэлтэй танилцсан: Хурлын дарга

 И.Дариймаа

Тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Г.Уянга

